



**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2018 оны 2 сарын 6 өдөр

Дугаар А-32

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хэлбэрийг нэвтрүүлэх зорилгоор Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газрын захирал (Н.Батсайхан), Дотоод аудитын газар (Д.Аюуш)-т тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

1. Нийтлэг үндэслэл

ФАТФ-ын 40 Зөвлөмжийн 1-р зөвлөмжид зааснаар улс бүр өөрийн үндэсний Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй тэмцэх тогтолцооны эрсдэлийг үнэлж эрсдэлтэй, сул талуудыг тодорхойлох үүрэг хүлээдэг. Үүний зэрэгцээ бүх банк, санхүүгийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаанаас үүдэн гарах МУТС эрсдэлийг үнэлж, түүнийг бууруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах нь ФАТФ 40 зөвлөмж болон дотоодын хууль тогтоомжид заасан шаардлагуудын нэг юм. Энэ хүрээнд банк санхүүгийн байгууллагууд өөрийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийж, түүний дүгнэлт болон үнэлгээнд ашигласан баримт, мэдээллийг байнга шинэчилж байх үүрэгтэй бөгөөд эдгээр баримт мэдээллийг Монголбанкны шаардлагаар гаргаж өгөхөд боломжтой хэлбэрээр хадгалах үүрэгтэй.

Иймд банк, санхүүгийн байгууллагууд нь Монгол Улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал болон МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээ, өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан Монгол Улсын дотоод болон гадаадын хувь хүн, хуулийн этгээдтэй тогтоох санхүүгийн харилцаанаас үүдэн гарах МУТС эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, мониторинг хийх, хяналт тавих болон эрсдэлийг бууруулах үр дүнтэй тогтолцоотой байх шаардлагатай.

2. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа

2.1 Эрсдэлийг тодорхойлох

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны эхний үе шат нь эрсдэлийг тодорхойлох явдал юм. Банк санхүүгийн байгууллагад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл нь харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх суваг, арга хэлбэр, газарзүйн байршил, ерөнхий эдийн засгийн болон гэмт хэргийн нөхцөл байдал зэрэг хэд хэдэн хүчин зүйлүүдээс бий болдог. Банк эрсдэлийн үнэлгээг хийхдээ дээр дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж үүсэж болзошгүй МУТС эрсдэлийг тодорхойлох шаардлагатай. Банк, санхүүгийн байгууллагууд нь МУТС Монгол Улсын эрсдэлийн ерөнхий нөхцөл байдлыг Үндэсний эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан үнэлнэ. Тухайлбал, Монголбанкны веб сайтад (www.mongolbank.mn) байршуулсан Монгол улсын МУТС үндэсний эрсдэлийн үнэлгээг ашиглаж болно. МУТС эрсдэлийн үнэлгээг үндэсний түвшинд үнэлэх хүрээнд МУТС-тэй холбоотой заналхийлэл, эмзэг байдалтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлсон. МУТС заналхийлэл нь улсын хэмжээнд гарч буй гэмт хэргийн түвшинтэй шууд харилцан хамааралтай байна. МУТС үйл ажиллагаанд өртөж болзошгүй эмзэг байдал нь улс төр (улс төрийн тогтолцооны шинж чанарууд), эдийн засаг (эдийн засгийн нөхцөл байдал), нийгэм (хүн амын үзүүлэлтүүд), технологи (техник, технологийн дэвшил), байгаль орчин (байгаль орчинтой холбоотой асуудлууд), хууль эрх зүй (хууль, эрх зүйн тогтолцооны үр дүнтэй байдал, үйлчилж эхэлсэн хугацаа, хамрах хүрээ,) гэх зэрэг зэрэг хүчин зүйлүүдээс шууд хамаарна.

2.2 Эрсдэлийг үнэлэх

Эрсдэлийг тодорхойлох нь үр дүнтэй эрсдэлийн удирдлагын тогтолцооны эхний алхам юм. Эрсдэлийг тодорхойлохоос гадна түүнийг үнэлэх нь мөн чухал ач холбогдолтой. Тодорхойлсон эрсдэлийн төрөл, хүчин зүйлс нь банкны үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, нөлөөллийг хэмжээг үнэлж эрэмбэлэх ажил энэ хүрээнд хийгдэнэ. Иймд банкууд МУТС эрсдэлийн хүчин зүйлс тус бүрийг үнэлэх, эдгээр эрсдэлийн гарч болох цаг хугацаа, тохиолдлыг тодорхойлох арга техник, тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай. Хэрэв банк тодорхой төрлийн харилцагчийг өндөр эрсдэлтэй гэж үзвэл, тухайн төрлийн харилцагчдын тоо, бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ, хийж буй гүйлгээнд нь тогтмол хяналт тавих үүрэгтэй.

2.3 Эрсдэлд хяналт тавих

МУТС эрсдэлийг тодорхойлон үнэлсний дараа эрсдэлийг бууруулах үр дүнтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоо, сайн туршлагыг бий болгох шаардлагатай. Банкуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийн бодлого, эрсдэлийн удирдлагын аргачлал, баталсан бодлогыг хэрэгжүүлэх буюу урьдчилан таамаглаагүй эрсдэлийн төвлөрлийг бий болохыг хязгаарласан журам, зааврыг хамарна. Түүнчлэн эрсдэлийн хяналтын хүрээнд албан тушаалтнуудын эрх, үүргийг тодорхой зааглаж өгөх нь чухал үүрэгтэй. Үүний зэрэгцээ эрсдэлд үр дүнтэй байдлаар хяналт тавих үйл ажиллагаа нь МУТС эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг бүх албан, тушаалтан, нэгж хоорондын хамтын ажиллагаа, дотоод бодлого, журам, хязгаарлалттай холбоотой мэдээллийг саадгүй солилцох болон эрсдэлийн түвшинд нь тохирсон арга хэмжээг шуурхай авч ажиллахаас ихээхэн хамаарна.

2.4 Эрсдэлд мониторинг хийх

Банкууд МУТС эрсдэлийн хүчин зүйлс, тэдгээрт гарч буй өөрчлөлт, чиг хандлагыг байнга хянаж байх мониторингийн тогтолцоог бий болгох шаардлагатай. Банкууд эрсдэлийн удирдлагын мэдээллийн системтэй байх ёстой бөгөөд энэ систем нь МУТС суурь эрсдэл, түүний өөрчлөлтийг үнэлдэг байх ёстой. МУТС эрсдэлийн удирдлагын хувьд энэ нь маш чухал юм, жишээлбэл, Удирдлагын мэдээллийн систем нь байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийн түвшингийн өсөлт, бууралтыг үнэлж байдаг. Түүнчлэн удирдлагын мэдээллийн систем нь МУТС үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй харилцагчийн сэжигтэй үйл ажиллагаа, гүйлгээг илрүүлэх зорилгоор түүний банкттай үүсгэсэн бизнесийн харилцааны хэв шинж болон гүйлгээд хяналт тавих боломжийг хангана. Мөн Удирдлагын мэдээллийн систем нь бодлого, журмын хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт тавих, шаардлагатай зохицуулалт, дотоод хязгаарлалтыг өөрчлөн сайжруулах дохиог өгч байдаг.

2.5 Эрсдэлийг бууруулах

Дээр дурдсан арга хэмжээг үр дүнтэй байдлаар шат дараатай хэрэгжүүлбэл МУТС эрсдэлийг бууруулах боломж бүрдэнэ.

3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

3.1 Зохистой засаглал

Банкны бүх үйл ажиллагаа ил тод, хариуцлага, хариуцлагатай, ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлан зохистой засаглалын хүрээнд явагдах шаардлагатай. Банкууд нийт ажилтнуудын ёс зүйг өндөр түвшинд байлгах Ёс зүйн хэм хэмжээг тогтоож мөрдүүлэх шаардлагатай. Зохистой засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд үр дүнтэй, хэрэгжих

хамарсан байна. Дотоод бодлого журмыг баримт, бичиг болгон батлуулж бүх ажилтнуудад танилцуулна. Мөн банкны МУТС эрсдэлийн хүчин зүйлс, тэдгээрийн түвшинд гарч буй өөрчлөлтийг үр дүнтэй удирдах зорилгоор бодлого журмыг үр дүнтэй байдалд хяналт тавьж шаардлагатай өөрчлөлт шинэчлэлийг ТУЗ-д танилцуулах шаардлагатай.

Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд ажилтнуудын үүрэг, хариуцлагыг зааглах, МУТС эрсдэлийн удирдлагын чиг үүрэгт хамрагдаж буй бүх ажилтнууд, нэгжүүдийн мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох шаардлагатай. Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгохын тулд банкны хүлээн зөвшөөрөх МУТС эрсдэлийн хязгаарыг тогтоож өгөх нь зүйтэй. Энэ хүрээнд МУТС бодлого журамд, тодорхой төрлийн харилцагч, бүтээгдэхүүн, түүнийг харилцагчид хүргэх суваг, зах зээл, газарзүйн байршлаас үүсэж болзошгүй эрсдэлд хязгаарлалтууд тавина. МУТС үр дүнтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь дээр дурдсан тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн тохиолдол болон түүний давтамжийг тайлагнах боломжтой мэдээлэх механизмыг бүрдүүлсэн байна.

3.3 Дотоод хяналтын хөтөлбөр

Байнгын дотоод хяналтын тогтолцоо нь эрсдэлийн удирдлагын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Банк батлагдсан бодлого, журам, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, заавар, удирдамжийг хэрэгжүүлэх үүднээс тогтмол арга хэмжээ авах шаардлагатай. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс “дөрвөн нүд”-ний зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Жишээлбэл, үйлчилгээний болон арын албаны ажилтнуудын буюу үйл ажиллагааны болон хяналтын чиг үүргийг хооронд нь ялгаж тусгаарлах арга хэмжээ авах хэрэгтэй. Банкны МУТС эрсдэлийн удирдлагын хяналтын тогтолцоонд хөндлөнгийн аудит, хяналт шалгалт хийгддэг байна.

3.4 Дотоод аудит

Банк дотоод аудитын үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай. Дотоод аудит нь банкны ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд тайлагнадаг, бие даасан, хараат бус байна. Дотоод аудитын чиг үүрэг нь банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг тодорхой давтамжтайгаар үнэлэх, шалгах баталсан бодлого, журам, хязгаарлалт, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хамарна.

3.5 Комплаенсийн чиг үүрэг

Банк МУТС эрсдэлийн удирдлагын тогтолцооны нэг хэсэг болох комплаенсийн чиг үүргийг нэвтрүүлэх шаардлагатай. Комплаенс нь байгууллагын бизнес загвар, үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанартай нийцтэй байна. Комплаенсийн чиг үүрэг нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг учраас дотоод аудитаас ялгаатай чиг үүрэг юм.

Комплаенсийн нэгж нь банк холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, удирдамжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих үүрэгтэй. Комплаенсийн үйл ажиллагааны үр дүнтэй байдал банкны удирдлагын мэдээллийн систем нь МУТС эрсдэлийн удирдлагатай холбоотой мэдээллийг хэр үнэн зөв, цаг тухайд нь боловсруулж чадаж байгаагаас ихээхэн хамаарна.

Банк МУТС эрсдэлд хяналт тавих комплаенсийн ажилтантай байна. Комплаенсийн ажилтан нь эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд удирдлагаас хараат бус байдлаар сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй байна. Комплаенсийн ажилтан нь харилцагчийн талаар банкинд байгаа бүх бичиг баримт болон гүйлгээний мэдээлэлд нэвтрэх, гаргуулж авах эрхтэй байна.

Энэ эрх нь Санхүүгийн нэгдлийн хэмжээнд болон салбар, охин компаниудаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах эрх хэмжээг мөн хамаарна.

3.6 Эрсдэлд мониторинг хийх, тайлагнах

Банк МУТС эрсдэлийг үр дүнтэй удирдаж бууруулахын тулд МУТС эрсдэлийн түвшин, түүний шинж чанар, эрсдэлийг бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх талаар бодит мэдээлэл өгдөг мэдээллийн удирдлагын системийг нэвтрүүлсэн байх шаардлагатай. Мэдээллийн удирдлагын систем нь банкны өөрийн бизнесийн загвар, үйл ажиллагааны цар хүрээтэй нийцтэй байна. Энэ мэдээллийн удирдлагын систем нь МУТС эрсдэлийн түвшин, шинж чанарт гарсан өөрчлөлтүүдийг тогтмол үнэлж байх ёстой бөгөөд эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлого, журмын хэрэгжилтийн талаарх мэдээллээр гүйцэтгэх удирдлага, бизнес нэгжүүдийг цаг алдалгүй хангадаг байх шаардлагатай. Түүнчлэн мэдээллийн удирдлагын систем нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам, заавар, хязгаарлалт болон холбогдох хууль, тогтоомжид заасан үүргийг зөрчсөн тохиолдлыг тайлагнах, мэдээллийн сан үүсгэн хадгалах гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийг шаардлагатай мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн байна.

3.7 Сургалт

Банк бүх ажилтнууддаа МУТС-тэй тэмцэх хууль эрх зүйн орчин, Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр хүлээсэн үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дотоод бодлого, журам, зохицуулалтын талаар тогтмол сургалт зохион байгуулж байхыг шаардана. Ажилтнууд нь банкны бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн гарах МУТС эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээ болон тухайн ажлын байрны онцлогоос хамааран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой мэдлэг, ойлголттой байх нь чухал юм. Ажилтнуудад зориулсан сургалт нь тасралтгүй, тусгай хөтөлбөрийн дагуу хийгддэг байна. Бүх ажилтнуудад зориулсан ерөнхий сургалтаас гадна ажилтнуудын чиг үүргийн онцлогоос нь хамааруулан тодорхой бүлгийн ажилтнуудад тусгай хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай. МУТС-тэй тэмцэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд ТУЗ-ын гишүүдэд тохирох сургалтыг зохион байгуулна.

_____оОо_____